

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ 1/713 ТООТ АЛБАН
БИЧГЭЭР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.

2023.12.08

№	Зөвлөмж	Хэрэгжилт
1.	Мэдүүлэгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, тэднээс эрх үүргээ хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах.	Сумын мэдүүлэг мэдүүлэгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар сумын ЗДТГ-ын дарга ажиллаж байна. Мэдүүлэгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан нь АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг бүртгэх, хянах, хадгалах, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам"-ын төрийн байгууллагын удирдлагуудтай холбоотой зүйл заалтуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна.
2.	Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхолын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхолын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгууллалтын арга хэмжээ авах.	2023 оны 11 сард төрийн байгууллагуудын удирдлага, төрийн захиргааны албан хаагчид ХАСУМ гаргах, мэдэгдэл тайлбар гаргах түүнд анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулсан. Мэдэгдэл тайлбарын албан хаагч томилох, үнэлгээний хороо байгуулах, хяналт шалгалт хийх, ажлын хэсэг байгуулах, газар олгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулах зэрэгт тухай бүр гаргуулж хэвшсэн. Мэдэгдэл тайлбарыг гаргуулж АТГ-ын цахим системд бүртгэж хэвшсэн. 2023 онд нийт 48 мэдэгдэл тайлбар гаргуулж ажилласан байна.
3.	Нийтийн албан тушаалд томилогдсноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах.	2023 оны 11 сарын байдлаар ХАСУМ хянуулах шаарлагатай 5 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хянуулж томилсон. Эдгээр албан тушаалтнаар хуульд заасан 30 хоногийн дотор Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргуулсан. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ хугацаандаа гаргаагүй зөрчил гараагүй.
4.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхолын урьдчилсан	2023 оны 11 сарын байдлаар ХАСУМ хянуулах шаарлагатай 5 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хянуулж томилсон. Нийтийн албанд

	мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох.	томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчил гаргаагүй.
5.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчин хандив авч буй үйлдлийг нэг мөр таслан зогмоох, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх.	Төрийн байгууллагын удирдлагуудад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар сургалт зохион байгуулсан. Сумын хэмжээнд хууль зөрчин хандив авч буй үйлдэл гараагүй.
6.	Худалдан авах чиглэлээр мэргэшсэн ажилтан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг олон давтамжтай хамруулахгүй байх, ашиг сонирхолын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.	2023 онд Худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээтэй хүмүүсийг нэмэгдүүлэх зорилгоор уг сургалтанд шинээр 3 иргэн 4 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Үнэлгээний хороонд иргэний төлөөллийг аль болох давхцуулахгүй оролцуулах ажлыг зохион байгуулж байна.
7.	Тендерт оролцогчдын эрхийг зөрчих, бусдад давуу байдал үүсгэх, тендерийг нэр төдий зохион байгуулж байгаад дүгнэлт хийх, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх.	2023 оны худалдан авах ажиллагаанд тендерт оролцогчдын эрхийг зөрчих, бусдад давуу байдал үүсгэх зөрчил гараагүй. Үнэлгээний хороонд ажиллаж буй албан хаагч, хөндлөнгийн төлөөлүүдэд авлига ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийг тайлбарлан таниулж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах баталгаа гаргуулж хэвшсэн.
8.	Засаг даргын нөөц хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаад дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг чангатгах, ялангуяа баяр ёслол, тэмцээн, уралдаан, наадам, шагнал, урамшуулал, дайллага, хүндэтгэл үзүүлэх, хайрхан тайх, буцалтгүй тусламж олгох, зэрэг арга хэмжээнд уг хөрөнгийг зарцуулахгүй байх.	Оны эхэнд сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах ажлын төлөвлөгөө, зардлын тооцоог гаргаж тэдгээрийн гүйцэтгэлд тулгуурлан Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулж байна.
9.	Орон нутагт төрийн алба, төрийн жинхэнэ албан хаагчийн улс төрийн намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах, нөхцөл бүрдүүлэх, төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй байх.	2023 онд батлагдсан Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчидад сурталчлан сургалт зохион байгуулсан. Төрийн албан хаагчдыг хуулийн дагуу улс төрийн аливаа намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах талаар анхаарч албан хаагч бүрээс баталгаа гаргуулж авсан. 2023 онд төрийн албан хаагч намчирхах, улс төрийн намын нөлөөлөд орсон, зэрэг зөрчил гараагүй.
10	Төсвийн хэтрэлт, хэмнэлт, үр ашигтай байдлыг нарийвчлан тооцож, шаардлагагүй зардлыг тэвчих, "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн	Төрийн бүх байгууллагын санхүүгийн гүйлгээ цахим системд шилжсэн. "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг төрийн бүх байгууллагын түвшинд хангуулан ажиллахад анхаарч, төсвийн үр

хэрэгжилтийг төрийн бүх шатны байгууллага, нэгжийн түвшинд хангуулан ажиллахад анхаарах, түүнд тавих хяналтыг сайжруулах.	ашигтай байдлыг нарийвчлан тооцож, шаардлагагүй зардлыг тэвчих замаар төсвийн хэтрэлтгүй, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна.
---	--

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН: СУМЫН ЗАСАГ ДАРГА



Б.ИЧИННОРОВ.

Б.СУГАР.